

Лекц №14

ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ БА УРЛАГИЙН БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТУРШЛАГА

АГУУЛГА

1. Шинэ хэвийн байдлын тухай ойлголт,
2. Титэмт нянгийн хижиг тахал нийгмийн сэтгэл зүйд хэрхэн нөлөөлөв?
3. Шинэ хэвийн байдал ба урлагийн салбар
4. Шинэ хэвшил – Сүржин тунхаглал уу? Бодит өөрчлөлт үү?
5. Бид юу хийх вэ? - (Шинэ хэвийн байдалд шилжихэд урлагийн үүрэг, оролцоо)
6. Түүхэн дэх шилдэг бүтээлч туршлагаас судалж эхэлье!

Шинэ хэвийн /нөхцөл/ байдал гэдгээр аливаа нэг хямарлын дараах байдал, хямралаас өмнөх байдлаас ялгаатай байгаа төлөвийг нэрлэдэг юм байна. Яг одоогоор бол COVID-19 цар тахал дэлгэрснээс хойшх одоогийн нөхцөлийг хэлж байна. Энэ нөхцөлд танд ямар ямар өөрчлөлтүүд бий болсон байна түүнийг л хэлээд байх шиг байна. Гэхдээ нийтлэлүүдийг харж байхад эдийн засаг, нийгэм, нийгмийн эрүүл мэнд гэх мэтийн нөхцөл байдлыг илүү их ярьж, бичиж байх шиг байна. Уг нь гол нь хүн л анхаарлын төвд баймаар санагдах юм.

Гэхдээ хүний асуудлыг бас анхаараагүй ч биш, анхаарч л байгаа. Гэхдээ эрүүл мэнд, эмнэлэг үйлчилгэндээ илүү анхаараад хүний сэтгэл санааны тогтвортой, тайван байдлыг бага анхаарч байх шиг байна. Гадаадын судлаачид ч бас үүнийг судлаад тогтоосон байна лээ. Үүнд урлаг л гол үүрэгтэй байх болов уу!

1. ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Шинэ хэвийн байдал буюу “New Normal Era” гэсэн нэгэн ойлголт, тэрхүү ойлголтоор илэрхийлэгдэх үйл явц, үйл ажиллагааны тухай их сонсогдох болжээ. Сонсогдохоор ч барахгүй олон улс ороны эрдэмтэн судлаачид салбар бүрээр судалгаа шинжилгээний ажил хийж, төрийн хэмжээний бодлого боловсруулж, хэрэгжүүлж байгаа ажээ.

“New Normal Era” гэх энэ нэр томъёо 2007-2008 оны санхүүгийн хямралын дараа хэрэглээнд орж ирсэн бөгөөд дэлхий нийтийг донсолгооноос улбаатай нийгэм, эдийн засгийн байдлыг тодорхойлж дүрсэлхэд ашиглагдаж байжээ.

Өнөөдөр, Ковид-19 хижиг тахлын үед, Шинэ Хэвийн Байдал гэдгээр эдийн засаг, санхүү гэхээс илүү нийгмийн бусад олон салбарыг нийтэд нь хамарсан шинэ үзэгдлийг, өчигдөрхөн хэвийн бус байсан зүйлс өнөөдөр хэвийн, жирийн болоод байгаа энэ үзэгдлийг илэрхийлж байх шиг байна.

Гэхдээ үүнтэй санал нийлэхгүй байгаа, “бүх юм - амьдрал тэр чигээрээ орвонгоороо эргэчих юм бишээ” гэсэн үзэлтэй социологчид хүмүүс цөөнгүй байна. Хөл хорио, хил хязгаар зөөлрөөд ирэхээр яваандаа ихэнх зүйлс эргээд хуучиндаа орж, автобус, метро, галт тэргээрээ хуучнаараа зорчиж, анд нөхдүүд аялал зугаалганд явдгаараа явж, ая тухтай хуучлан сууцгаах л болно. Мэдээж, эрүүл ахуйн зарим шинэ хэвшил амьдралд тогтох л байх, тэр нь ч хэрэгтэй, гэхдээ хүмүүсийн хоорондын нөхөрсөг харилцаа хөндийрөөд, бие бинээсээ “зай барьдаг” болчих нь юу л бол гэж.

2. ТИТЭМТ НЯНГИЙН ХИЖИГ ТАХАЛ НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨВ?

Коронавирусээс үүдэлтэй нөхцөл байдал онцгой гойд. Олон хүний амьдралд хэзээ ч байгаагүй тийм өөрчлөлтүүд их гарсан. Тэдгээр өөрчлөлтүүд нь хэмжээ масштабаараа ч, шинж чанараараа ч урьд хожид байгаагүй.

Социологийн хүрээнд үүнийг “Айдсын тахал” гэж нэрлээд амжсан. Хэдхэн сарын дотор сая сая хүмүүс амьдралын утга учраа алдах дотоод айдаст өртсөн. Бараг хүн бүр өөрөөсөө асуусан байх: “би ер нь хэн юм бэ? Гэр бүлдээ, ажил дээрээ, улс орондоо би хэн юм бэ?”, хэрэв тахал бүхнийг орвонгоор нь өөрчилбөл яах вэ? гэж.

Хувь хүмүүсийн хоорондын харилцааны үнэ цэнийг нийгмийн ухамсар өөрөөр харж, төр улс, түүний институцийн хувь хүмүүсийн амьдралд үзүүлэх нөлөөг ч эргэн тунгаах болов. Иргэдийн эрх зүй, хууль цаазын ухамсар шинээр сэргэв.

Гэнэт л хэтийн төлөв – ирээдүй нь олон хүмүүсийг хоёр хуваав. Нэг хэсэг нь шууд л шийдвэр гарган “ханцуй шамлахад” бэлэн байхад нөгөө хэсэг нь “юу болохыг” харж хэсэг хүлээх санаатай.

Нэг үгээр хэлэхэд зүгээр нэг “үйлдэхэд бэлэн”, “хүлээхэд бэлэн” хоёр хэсэгт хуваахаас гадна дижитал технологийн тухайд “технооптимист” ба “технопессимист” болгон, “өөрчлөлтийг дэмжигч” ба “өөрчлөлтөөс татгалзагч” болгон, бас “иргэн” ба “хамжлага” гэсэн ялгаа заагийг харуулав.

3. ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ БА УРЛАГИЙН САЛБАР

Цар тахлын улмаас биометр, ариун цэврийн шаардлага хангаагүй урлагийн болон бусад үзвэр, үйлчилгээний газруудыг хаахад хүрсэн тохиолдол гадаад, дотоодгүй л байсаар байна. Ийм байдлаар дэлхий даяар урлагийн байгууллагуудыг хямралын үеэр түр хаасны улмаас, мөн эдийн засгийн хүндрэлээс болж дахин хэзээ ч нээгдэхгүй байх магадлалтай гэнэ. Энэ байдал урлагийн олон төрлийн байгууллагуудад янз янзаар л нөлөөлж байгаа бололтой. Тухайлбал, зарим газар үйл

ажиллагаа зогсоосны улмаас орлого нь огцом буурсан, долоо хоногт дунджаар 20,300 евро алдаж, хандив, ивээн тэтгэлэг нь багасаж санхүүгийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулж байна. Энэ нь ажилчдын цалинг бууруулж, цомхотголд орсон бололтой (түр ажилтан, зуучлагч зэрэг гадаад гэрээ, улирлын чанартай ажилчид, үзэсгэлэн, каталог хэвлэх, боловсролын материал, арга хэмжээ болон бусад арилжааны үйл ажиллагаатай холбоотой ажил).

Энэ бүхэн цаашид бүхэл бүтэн нийгмийг зайн аргад хүргэнэ. Энэ нь урлагийн байгууллагын орчинд үйл ажиллагаа явуулж буй компаниуд болон фрилансерууд оршин тогтноход бүтцийн аюул заналхийлж байгааг харуулж байгаа ба улмаар эдгээр мэргэжилтнүүдэд, бүтээлч үйл ажиллагаанд түшиглэсэн бусад соёлын болон бүтээлч салбаруудад нөлөөлөх магадлал улам бүр нэмэгдсээр байна.

Коронавируст халдвар (COVID-19)- ийн хөл хорионы үед болон улс орны нөхцөл байдлаас шалтгаалан жижиг бизнес эрхлэгчдэд ажлын байрыг хадгалахад туслах зорилготой ажлын байрыг хадгалах тогтолцоонд ашгийн бус байгууллагуудыг оруулах асуудлыг авч үзэх нь чухал юм. Мөн тус салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хандив, буяны үйлсэд тусгайлан зориулсан татварын хөнгөлөлтүүдийг авч үзэх нь зүйтэй (жишээ нь дүрслэх урлаг, тайзны урлаг гэх мэт харьцангуй эмзэг дэд салбаруудын залуу бүтээлч мэргэжилтнүүдийг тусгайлан дэмжих) гэх мэтийн санал санаачлагууд ч гарч байна.

Эдгээр асуудлууд олон улсын судалгаагаар тогтоогдсон зүйлс боловч бид арай өөрөөр, нөгөө өөр аргаараа энэ байдалд хандах нь үр дүнтэй, бусдад ч гэсэн ашиг тустай байх болов уу!

4. ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ – СҮРЖИН ТУНХАГЛАЛ УУ? БОДИТ ӨӨРЧЛӨЛТ ҮҮ?

Зарим нь ярьж байна:

Бүх зүйл эргээд хэвэндээ орж л таараа, санаа зоволтгүй гэж, нөгөө хэсэг нь: маш их өөрчлөлт гарна хорвоо дэлхий хуучнаасаа шал өөр болно, амьдралын хэв маяг, түүнээ дагаад хүмүүс өөрчлөгдөнө гэж. Ямар ч гэлээ хөл хорио, тусгаарлалт, зай барилтын олон олон үр нөлөө – эффектийг бид үзэх л болно.

Эдийн засаг хамгийн гол, нүднээ ил өөрчлөлт болох нь шиг байна. Ямарч байсан “ядуу” эдийн засаг руу шилжих нь бололтой шиг байна. Тэр нь илүү тогтвортой, илүү ухаалаг, илүү ариг гамч эдийн засаг байна – дижитал эдийн засаг.

Энэ шинэ эдийн засаг нь амьдралын үнэ цэн, баялгийн үнэ цэн, утга учрыг ухаарсан шинэ нийгэм бүрэлдүүлж эхэлнэ.

Түүхээс үзвэл, ийм маягийн томоохон хямралууд дандаа үнэ цэнг эргэн харж, эрэмбэ зиндааг шинэчлэн тогтоож ирсэн байдаг. Ялангуяа залуус үүнд их идэвхтэй оролцогч, бас нөлөөлөгч нь байдаг. Ханган нийлүүлэлт, хүргэлт үйлчилгээ, үүнийг дагаад хүмүүсийн хоорондын нийгмийн харилцаа, төр засгийн үүрэг ач холбогдол... Тахал нийгмийн ухамсарыг өөрчлөөд, өөрчлөгдсөн тэр ухамсар өөр, шинэ бодит байдал, шинэ нийгмийг бүтээн босгоно.

Онлайн үерийн ус мэт л офлайн-ыг түрэн орж ирлээ. Нийгмийн бүх салбарт дижитал технологи хүссэн хүсээгүй “хүзүү ороон” хүрч ирлээ. Энэ бодитой бөгөөд маргаангүй юм. Тэртэй тэргүй хямарч байсан зүйлийг хижиг тахлын хөл хорио бүр хурдасгаад, хурдасгахаар барахгүй хуйлруулаад хаячихлаа.

Хямрал юунаас болсон бэ гэхээр: ШУТ дэвшлийн (оюун ухааны дэвшил гэж бас ойлгож болох мэт?) төсөөлөшгүй тэр их хурднаас хүн төрөлхтний нийгэм, соёл-үзэл санааны хөгжил (культурно-духовный) хэт хоцорчихжээ. Араас нь нэхээд гүйцэх ч үгүй, амдаж тосоод нийлээд авах аргаа л бодох хэрэгтэй байх.

Хар бор жишээ авбал: хүн тархиа хөгжүүлж (ш\у), машин (техник технологи) хийсээр байгаад формула-1 (F1) гэсэн “галзуу” машинтай болжээ өнөөдөр. Харин жолооч нь өөрөө бие бялдраараа ч, сэтгэл зүрхээрээ ч олигтой хөгжөөгүйгээр барахгүй хүний мүсээр бүр муудсан байвал яахуу? Зарим либераль, толерант үзэл нь завхарч гүйцээд учраа олохоо больсон. Завхралтайгаа “зохицож” амьдрах юм яриад сууж байгаа ийм жолооч тэр техникийн гайхамшиг болсон машиныг жолоодох уу? Осолд орж эрэмдэг зэрэмдэг болно биз дээ? Эсвэл машинтайгаа, өөртэйгээ сүйрнэ.

Ийм юм болох нь тодорхой байна шүү гээд зуу зуун жилийн өмнөөс хэлээд сануулаад байсан улсыг бид “солиот” гэж хочлоод тоогоогүй (үүнд урлагийн алдартнууд цөөнгүй тооцогдоно) бол харин Бурхан өөрөө бидэнд шууд харуулаад байгаа юм биш биз?

Соёл урлаг, боловсрол, хувийн хөгжилд гарах өөрчлөлтүүд

Пандемийн үед соёл, үзвэрийн салбарт ихээхэн өөрчлөлт орж, виртуаль хэлбэр рүү шилжсээр байна. Угаасаа онлайн, виртуаль орчин руу хандчихсан байсан энэ чиглэлийн хөдөлгөөн цар тахлын нөлөөгөөр цаашид улам эрчимтэй явагдах нь тодорхой харагдаж байна.

Бодит “амьд” харилцааны хил хязгаар хумигдсан ийм үед виртуаль буюу материаллаг бус ертөнцийн хил хязгаар тэлж холбоо харилцааны технологийн

ололтоор зуучлуулан урлаг соёл, боловсролын үйлчилгээг хүмүүс гэр орондоо, ажлынхаа байран дээр авах боллоо.

Интернетийн орчин боловсрол, соёл урлагийн үйлчилгээний нийтлэг талбар болж биеэр очихгүйгээр бодит боловсрол, мэдлэг мэдээлэл авч, сэтгэлийн цэнгэл, оюуны таашаал эдлэх боломж олгож байна. Энэ нь хэрэглээний шинэ тогтолцоо, үнэлгээний өөр өөр шүүлтүүрийг бий болгон салбарын удирдлага менежментийн загварыг шинэ шатанд гаргахыг шахан шаардаж байгаа нь харагдана.

Хувийн хөгжил, боловсрол

Гипотеза – Таамаглал: Хүмүүс хувийн хөгжил, цахим боловсролд анхаарал хандуулж, төлбөртэй үйлчилгээ, сургалтаас ч татгалзалгүй олноороо хамрагдах болно.

Ойрын прогноз (1-3 жил): Онлайн боловсролын ахисан болон нэмэлт төлбөртэй хэлбэрүүд цаашид цар тахлын дараа ч эрчээ алдахгүй түгэх болно. Ингээд мэргэжлээ ахиулж нарийн мэргэжилд мэргэших, дуртай сонирхолтой өөр мэргэжилд хөрвөх, хөл хорионы үед ч ажил орлогоо алдахгүй зайнаас ажиллах горимд шилжих зэрэг боломжууд өргөн нээгдэнэ.

Дунд хугацааны прогноз (5-7 жил): Төлбөртэй, нэмэлт ахисан түвшний онлайн сургалт улам илүү хөгжсөөр салбартаа бие даасан институци болон бүрэлдэж, яваандаа уламжлалт бусад сургалтуудтай өрсөлдөх хэмжээнд хүрнэ.

Хөл хорио нь нийгэм, боловсрол, соёлын харилцааг хязгаарласан тул өөртөө, гэр бүлдээ зориулах зөндөө цаг гараад ирсэн хэрэг. Өөрчлөлтөнд бэлэн хүмүүст бөөн “цагийн олз”. Дээрээс нь цахимаар гэртээ байж байгаад ханьтайгаа, хүүхдүүдтэйгээ хамтдаа бүхнийг хийх боломж байна.

НАФИ-гийн судалдгаагаар Оросын иргэдийн 36% нь хувийн хөгжил, боловсролоор занималдсан байна. 18-25 насныхан бол бүр 59%. Ерөөсөө энэ насныхан санхүү, боловсролын идэвх өндөр, дасан зохицох чадвартай, өөрчлөлтөнд бэлэн байх хандлагатай. Тэд ихэнхдээ гадаад хэл сурч, ном уншиж кино үзэж байна.

Соёл урлаг, чөлөөт цаг

Цар тахлын үед соёл урлаг, чөлөөт цаг, үзвэрийн үйлчилгээ дасан зохицох гайхалтай чадварыг харуулсан нь нэг сод үзэгдэл болов. Тэд цахим хэлбэрт маш уян хатан шилжиж, богино хугацаанд үйлчлүүлэгч, үзэгчидтэйгээ эргэн холбоо тогтоож виртуаль орчинд тэдэндээ үйлчилж, онлайнгаар үзвэрээ түгээж чадсан байна. НАФИ судалгаагаар цахим үзвэрт зарцуулах хугацаа хуучнаасаа нэмэгджээ. Үүнд:

Кино, цэнгээнт нэвтрүүлэгт зарцуулах хугацаа

40% ихэссэн

Интернетэд болон чат-д зарцуулах хугацаа 33% +

Спорт 23% +

Судалгаагаар онлайн кино театруудын хэрэгцээ, хэрэглээ Facebook, Instagram-аас илүү гарчээ. Энэ нь зөвхөн “завтай” хэрэглэгчийн хүсэл сонирхолоос гадна онлайн платформуудын үйлчилгээгээ оновчтой хүргэж, чанартай хэрэгтэй контент боловсруулж ажилласантай бас холбоотой. Хоёр талын ашиг сонирхол нийцсэн гэсэн үг.

Судлаачдын үзэж байгаагаар пандемийн дараа энэ үзэгдлийн идэвх нэлээд суларна, тиймээс контентийнхээ агуулга, чанарт одооноос анхаарах хэрэгтэй гэнэ. Учир нь “амьд”, “оригналь” юмны татах хүч илүү байдаг нь маргаангүй үнэн билээ.

Моодны индустр бас сонин, тэгээд ч чухал!

Таамаглал: Онлайн форматад хамгийн амжилттай дасан зохицож яваа нэг салбар бол Моодны Индустр.

Ойрын прогноз (1-3 жил): Коронагийн дараа фэйшн категорийн борлуулалт нэлээд, мэдэгдэхүйц хэмжээгээр өснө. Гэхдээ хуучин хэмжээндээ хүртэл арай болоогүй. Судлаачдын ярьж буйгаар фэйшн индустрийн компаниудын 50 хүртэл % дампуурч болзошгүй гэнэ! Яагаад?

Пандемийн дараа хэрэглэгчийн сонголтын шүүлтүүр нь чанар, комфорт, практичность, энгийн, эко, минимализм байх гэнэ. Тэд орон нутгийнхаа үйлдвэрлэгчид захиалгаар гар хийцийг сонгох сонирхол нь дээшилнэ.

Дундын прогноз: Энэ салбарт E- худалдаа цаашид хөгжинө. Хүмүүсийн худалдан авалтын мотиваци нь өөрчлөгдөнө. Тэд хувцас хунар авахдаа “нэг удаагийн” моод хөөсөн байдлаасаа больж үүнийгээ “хөрөнгө оруулалт” гэж ойлгон, урт удаан хугацааны хэрэглээ гэж үзэх болно. Мэдээж, моодоо харах болно. Тиймээс эдэлгээ сайтай, ганцхан сезоны дараа моод нь хуучирчихгүй тийм сонголт хийх болно.

Хөл хорио, олон нийтийн ажлын хязгаар, аялал жуулчлалын зогсонги байдал зэрэг нь гардеробоо өөрчилж шинэчлэх хэрэгцээг бараг зогсоосон тул офлайн худалдаа эрс буурсан.

Одоогийн энэ нөхцөл байдал “Fast fashion”- ны эрин үеийн төгсгөл болж мэднэ. Суурь хэрэгцээ, эдэлгээний чанар, тохиромжтой таатай байдал илүү үнэлэгдэх магадлалтай. Залуусын дунд энэ хандлага илүү ажиглагдаж эхлээд тогтвортой тархаж байгаа нь олзуурхууштай.

Эко фешн, Грийн фешн зэрэг хандлага зүгээр нэг моод байхаа больж хэрэгцээнд нийцсэн чанар зонхилох болов уу.

Коронагийн дараа үнэ хямдралын “бум” болж тэр нь жижиг бизнесийг олноор нь унагаж мэднэ.

Загварын тал дээр бол “Sustainable fashion” буюу “Тогтвортой загвар”- ын хандлага голлох нь тодорхой болоод байна.

Өнөөгийн амьдралын бодит байдалтай холбоотойгоор зарим улс орны судлаачид шинэ онол ч гаргаж, дэвшүүлж байна. Нэг жишээ авч үзье!


Хэвийнжүүлэх үйл явцын онол (NPT):

Хэвийнжүүлэх үйл явцын онол (NPT) нь эв нэгдэл, танин мэдэхүйн оролцоо, хамтын үйл ажиллагаа, рефлексийн хяналт зэрэгт тулгуурласан онол юм. Жишээлбэл, ажлын мөн чанар өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор алсын зайн ажлын дадлыг нэвтрүүлэхэд анхаарлаа хандуулдаг. Зарим судалгааны хүрээлэнгүүд NPT-ийг ашиглан хүмүүсийн өнөөгийн сэтгэлгээ, хандлагыг судалж, судалгаа шинжилгээ, практик үйл ажиллагаанд шардлагатай мэдээлэл бэлдэж боловсруулж, зарим удирдамжийг санал болгох зэрэг ажлууд хийж байгаа ажээ.

NPT нь өнөөгийн нөхцөл байдлын улмаас үүсээд байгаа нарийн төвөгтэй үйл явцуудыг өдөр тутмын практикт суулгаж өгөх, тогтмолжуулахад түлхэц үзүүлж, хүндрэлийг сааруулах хүчин зүйлсийг тодорхойлдог (May et al., 2009; Murray et al., 2010).

Шинэ технологид суурилсан ажлын дадлага туршлагыг хүмүүст эзэмшүүлэх, түүнийг хэрхэн удирдаж болох зэргийг судалж, хэрэглэгдэх боломжийг бий болгоход чиглэсэн онол. NPT нь зан үйлийн томоохон өөрчлөлтүүд хэрхэн гарч ирдэгийг тайлбарлаж, хэрэгжилтэд нь анхаарлаа хандуулаад зогсохгүй, өөрчлөлт нь харагдахаас “алга болох” (өөрөөр хэлбэл энэ нь хэвийн болсон) хүртэл (Murray et al., 2010) ердийн практикт маш сайн уусч өгдөг байна. Тодруулбал, NPT нь ажлын нийгмийн зохион байгуулалт, түүний хэрэгжилт, дадлагыг өдөр тутмын амьдралын хэвшмэл элемент болгож суулгах, нийгмийн хүрээнд суулгасан дадлыг хадгалах (интеграцлал) зэрэгтэй холбоотой (2006 оны 5-р сар).

NPT нь дараахь онолын бүтцүүдээр дамжуулан технологид суурилсан шинэ ажлын дадлагыг хэвийн болгохын тулд тахал өвчний үед хэрэглэх боломжтой онол юм байна.



Технологид тулгуурласан ажлын шинэ туршилагын танин мэдэхүйн оролцоо:

Танин мэдэхүйн оролцоо нь COVID-19 тахлын үед шинэ практикийг бий болгож, тогтвортой байлгахын тулд ажилчдыг технологид суурилсан ажлын дадлагад анхаарлаа хандуулдахыг шаардаж байх шиг байна. Танин мэдэхүйн оролцооны хүрээнд санаачлага, хууль ёсны идэвхжүүлэлтийг шалгаж болно:

Санаачлага нь багийн гишүүд COVID-19-ийн үед технологид суурилсан ажлын дадлагад хэрхэн хувь нэмрээ оруулж байгааг шалгах боломжийг бидэнд олгодог. Жишээлбэл, ажилчдын болон үе тэнгийнхний хоорондын итгэлцлийн ач холбогдлыг харуулдаг бөгөөд энэ нь ажлын гүйцэтгэлийн мэдрэмж, ажлын сэтгэл ханамж, бүтээлч байдал, ажлын стрессийг бууруулдаг. (Эдмондсон, 1999; Гринбаум, 2019). ; Staples, 2001). Тухайлбал, алсын зайнаас ажиллаж буй багийн хувь нэмрийг баталгаажуулахын тулд даалгавартай холбоотой хурдтай харилцан үйлчлэлийг нэвтрүүлэх замаар багийн, нийгмийн бүтцийг хянах нь харилцаа холбоо, зохицуулалтыг ил тод байлгахад чухал ач холбогдолтой. Энэ нь багийн бүтээмж, гүйцэтгэлийн хувь хэмжээг хянах боломжийг олгодог. Ингэснээр тэдний техник технологид суурилсан ажлын практикт шууд хувь нэмэр оруулдаг.

5. БИД ЮУ ХИЙХ ВЭ?

(Шинэ хэвийн байдалд шилжихэд урлагийн үүрэг, оролцоо)

Ямар нэгэн дайн тулаан, байгалийн гамшиг, цар тахал дэгдэх гэх мэт давагдашгүй хүчин зүйлийн улмаас нийгэмд нийтийг хамарсан сэтгэл санааны хямрал ихсэдэг нь байгалийн жам ёсны мэт үзэгдэл юм.

Ийм үед нийгэм болоод хувь хүмүүс амьд үлдэх зөндөө хөтлөгдөх нь энгийн үзэгдэл бөгөөд төр улсын зүгээс нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт илүү их анхаарч бүх зүйлийг тэдгээр рүү хандуулдаг нь хэвийн үзэгдэл. Гэтэл хүмүүсийн сэтгэл, оюун санаа хоосорч, гүн хямралд оросон байдаг. Хүмүүс амьд үлдэхийн тулд амиа хичээх, зөвхөн өөрийгөө бодох үзэл нь дэвэрдэг байна. Чухам ийм болсон нөхцөлд хүмүүст эдийн засаг, эрүүл мэндээс илүүтэйгээр **урлаг** сэтгэл санааны хүч тамир өгч, хүн хэвээр үлдэх гол хүчин болдог. Иймээс урлагийг бусад хоёрын адил хэмжээнд авч үзэх нь чухал болдог.

Түүнчлэн, бид урлагийн олон төрөл зүйл, хэв маягуудаас аль нь нэн тэргүүний тохиромжтой болохыг судлан тодорхойлох хэрэг гарна. Бид бас үүнд энэ хичээлийн хүрээнд анхаарч үзэх хэрэгтэй.

Дараах нөлөө бүхий алдартэй гурван уран бүтээлчдийн бүтээлч сэтгэлгээний үр дүн, туршлагатай танилцан, тэдний үзэл санаа, бүтээлийн нийгэмд үзүүлэх нөлөөлөлийн тухай судлан ярилцаж, **бид юу хийх вэ гэдгээ тодруулах оролдлого хийцгэе!**

Түүхэн шилжилтийн үеүүд дэх зарим шилдэг уран бүтээлчдийн туршлагаас судалж үзье!

1. Альфред Кубин(1877- 1959)


“21 зууны “рациональ-ухаалаг” бидэнд 100 жилийн өмнөх Австрийн нэг зураач – “сонин товариц” ер нь юу хэлэх юм бол оо? Зурагнууд нь ихэнх үзэгчдэд ойлгомжгүй гайхал төрүүлж дургүйг нь хүргэнэ” гэж зарим хүмүүс эгдүүцдэг нэгэн.

Альфред Кубин дээр дурдсан, ...хүмүүс амьд үлдэхийн тулд амиа хичээх, зөвхөн өөрийгөө бодох үзэл нь дэвэрдэг... яг ийм зүйл болно гэдгийг урьдчидан мэдэж байсан юм биш биз! гэж бодогдмоор, тийм сэтгэлгээгээр бүтээлээ туурилдаг байсныг бид түүний бүтээлүүд болон “Нөгөө тал нь” гэдэг алдарт номноос нь мэдэх болно.

Кубины хар бараан авъяас анхнаасаа тэр үеийнхний анхаарлыг татдаг, түүний дотоод ертөнц нь тийм ч баяр баясгалантай биш. Өөрийн дотоод ертөнцийн дүр төрхийг л цааснаа буулгаж байсан гэдэг. Тэрээр нийгмийн шудрага бус, зальхай, заваан бүгдэд эгдүүцэн дургүйцдэг, бараг л бүгдийг үзэж яддаг байсан гэж судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. Бүр өөрийн аавыг ч үзэн яддаг нь бүр ч хачирхалтай. Магадгүй тэр шүүн тунгаахдаа гаргууд хүн байсан байх. Харин шүүн тунгаасан зүйлсээ үгээр бус, зураг дүрсээр илэрхийлж, бусдад өөрийн гэсэн өвөрмөц арга барилаар ойлгуулсан нь зөв гэж боддог байсан байх. Түүний шийдэл нь зөв

байх. Өөрийн эгдүүцэл дургүйцлээ шууд үг хэлээрээ илэрхийлэхэд хэн ч л дургүй байдаг хойно доо. Шийдлийн хэд хэдэн хувилбараас зурж, дүрсэлж ойлгуулах нь хамгийн оновчтой байж болно шүү дээ. Ер нь бараг ч тийм л болов уу!

Энэ бүтээлчийн талаар бид 11-р хичээлд бас үзсэн. Түүнийгээ эргэн санаарай!




2. Хандертвассер (1928- 2000):

Хандертвассер бага наснаасаа эхлэн урлагийн ур чадвараа хөгжүүлсэн. Дайны дараа тэрээр Вена дахь Дүрслэх урлагийн академид 3 сар ажилласан.

1970-аад онд Хандертвассер Шинэ Зеландын Арлуудын “Кауринуи” хөндийн нийт 372 га талбайг багтаасан хэд хэдэн үл хөдлөх хөрөнгө худалдаж авсан. Тэнд тэрээр байгальтай нягт холбоотой ажиллаж, амьдралынхаа мөрөөдлийг биелүүлсэн. Түүний анхны зүлгэн дээврийн туршилтууд тэнд бүтээгдсэн.

Тэрээр бүтээлдээ тод өнгө, органик хэлбэр, хүн төрөлхтнийг байгальтай эвлэрүүлэх, шулуун шугамыг үгүйсгэсэн хүчтэй индивидуализмыг нийтлэг ашигласан байдаг.

Тэрээр спираль зохиомжид илүү анхаардаг, шулуун шугамыг “бурхангүй, ёс суртахуунгүй”, “бодол санаа, мэдрэмжгүй, дүрэм журамтай хулчгар зүйл” гэж үздэг. Тэрээр өөрийн урлагийн онолыг “трансавтоматизм” гэж нэрлэсэн байдаг.



DuDu Children's Museum/ДүДү Хүүхдийн Музей

Nam June Paik(1932-2006):

Нам Жүн Паик- Америк-Солонгосын зураач, видео урлагийн үндэслэгч. Залуу насандаа Пик сонгодог төгөлдөр хуурчаар бэлтгэгдсэн. 1950 онд Солонгосын дайны үеэр Пайку болон түүний гэр бүл Солонгос дахь гэрээсээ дүрвэхэд хүрчээ. Тэд эхлээд Хонг Конг руу, дараа нь Япон руу нүүсэн. Зургаан жилийн дараа Пик Токиогийн их сургуулийг төгсөж, хөгжмийн зохиолч Арнольд Шоенбергийн тухай диссертаци бичиж байжээ.

Нам Жүн Паик хөгжмийн зохиолч Жон Кэйж болон түүний өдөр тутмын дуу чимээг хөгжимд ашиглах санааны нөлөөгөөр fluxus гэгддэг неоадада хөдөлгөөнд нэгдсэн. 1959 онд Пик "Homage a John Cage" зохиолыг толилуулжээ. Энэхүү тоглолт нь хүмүүс, тахиа, мотоцикль, янз бүрийн эд зүйлсийн бүтээсэн тайзан дээрх дуу чимээтэй урьдчилан бичсэн зохиолыг хослуулсан.

“Зурагт үзэж буй Будда” бүтээлээрээ Венецийн Биенналд оролцож тэргүүн байр эзэлж байсан. “Амьд барималд зориулсан зурагт” бүтээл нь ХХ зууны шилдэг бүтээлд тооцогддог. Энэ бүтээл нь тухайн үед эрчтэй дэвшигдэн гарч ирж байсан Фиминист философитой салшгүй холбоотой байдаг.

Видео инсталляц ажлуудаа хөдөлгөөнт үзүүлбэрийн (перформанс) урлагтай холбож хийдэг.

Пик роботуудыг дүрсэлсэн цуврал барималдаа телевизорыг оруулж эхэлсэн. Энэ төрлийн анхны бүтээлүүд нь голчлон утас, төмөр хэсгүүдээр хийгдсэн байдаг. Хамгийн анхны робот суурилуулсан нь 1965 оны Робот К-465 байсан. Дараа нь роботууд радио, телевизорыг асаасан. Зарим барималд нэг монитор багтсан бол бусад нь цуврал монитор ашигласан.

...Дүрслэх урлагийн түүхээс үзвэл, футурист уран бүтээлчид машин технологийн дэвшил хүний оюун ухаанаар бүтдэг урлагт байх ёстой гэдэг санааг дэвшүүлж, түүнийгээ хэрэгжүүлэхийг мөрөөдөж байжээ. Энэ нь Пайкийн уран бүтээлд биелэлээ олсон...[5]. гэсэн энэ түүх техник технологийн өнөөгийн хүрсэн төвшин болон цаашдын хөгжлийн чиг хандалага нь мөн л урлагт ихээхэн хүртээлтэй болохын баталгаа гэж хэлж болохоор байна.

Гэх мэт гайхалтай бүтээлч санаа, тэдгээрийн биелэлээр дүүрсэн уран бүтээлч байв.



ДААЛГАВАР

Энэхүү даалгаварт өгсөн 3 уран бүтээлч болон бүтээлийг би өөрийн үнэлэмжээр сонгосон тул та бүхэн багаараа ярилцаад сонголтоо өөрсдөө хийж болно. Сонголт хийхдээ сонголт тань тухайн цаг үеийн нийгмийн байдалтай хэрхэн уялдаатай байгааг нь онцлон анхаараарай!

Хэлэлцэх асуудал:

Эдгээр алдартай бүтээлчдийн бүтээл “Шинэ хэвийн байдал”- тай хэрхэн холбогдох вэ?

Шийдэх арга зам:

1-рт, 3 уран бүтээлчийн сонгосон бүтээлүүдэд анализ хийнэ.

Шийдвэрлэх асуудал:

1. Бүтээлүүдийн концепцийг тайлбарлах,
2. Бүтээлч сэтгэлгээний онцлогийг харьцуулж тайлбарлах,
3. 3 уран бүтээлчийн бүтээлүүдэд адилхан байгаа утга санааг олж тайлбарлах зэрэг болно.

2-рт, Дүгнэлт гаргахдаа анализийн үр дүнг “Шинэ хэвийн байдал”- тай холбон тайлбарлахыг хичээх нь чухал!

Ашигласан материал:

1. May & Finch, Implementing, Embedding, and Integrating Practices: An Outline of Normalization Process Theory. 2009
2. Murray et al. (2010) the open book of social innovation
3. "What Is Sustainable & Ethical Fashion?". Sustainable Jungle. Retrieved Oct 6, 2021.
4. "Why Slow Fashion Is The Need Of The Hour". Label. Retrieved October 6, 2021.
5. Уранчимэг Ц. XX зууны өрнөдийн урлаг / Ред. П.Оюунцэцэг.- УБ.: Art Design, 2002.- Х.163.
6. <https://nafi.ru>
7. <https://ru.wikipedia.org/wiki>
8. <https://karmannoe-zlo.livejournal.com/735053.html>
9. <https://en.unesco.org/news/preparing-youth-new-normal>
10. <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0268401220310252>